



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 17 өдөр

Дугаар А/600

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, 42 дугаар зүйлийн 42.2.1 "а" дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 8/04 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Алтайн буйлаастын орон сууцны дулааны шугамны засварт 4 000 000 төгрөг /дөрвөн сая/, "Гүнчандмань" 24 айлын орон сууцны сантехникийн засварт 4 000 000 /Дөрвөн сая/, Жаргалант сумын 9 дүгээр цэцэрлэгийн сантехникийн засварт 10 000 000 /Арван сая/, Жаргалант сумын 2 дугаар сургуулийн шугам сүлжээний засварт 5 000 000 /Таван сая/ төгрөг, нийт 23 000 000 /хорин гурван сая/ төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Дээрх засварын зардлыг аймгийн Орон нутгийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлэх хөрөнгө, оруулалт арга хэмжээний жагсаалтын 2,4-д тусгагдсан "Эрүүл мэндийн төвийн эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж"-ийн /Мөнххайрхан сум/ хэмнэгдсэн 1 100 000 төгрөг /нэг сая нэг зуун мянга/, 3.4-д тусгагдсан "Цэцэрлэгийн засвар"-ын /Мөнххайрхан сум/ хэмнэгдсэн 13 800 000 төгрөг /арван гурван сая найман зуун мянга/, 3.5-д тусгагдсан "Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын сантехникийн засвар"-ын хэмнэгдсэн 1 500 000 төгрөг /нэг сая таван зуун мянга/, 3.6-д тусгагдсан "Спорт заалны засвар"-ын /Мөст сум/ хэмнэгдсэн 7 500 000 төгрөг /долоон сая таван зуун мянга/-ийг тус тус санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Ганданповрон/ нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б. ДҮГЭРЖАВ



Зах А/600 ЧБ  
02 02966